



## НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ ДЭЭВЭР ЗАСВАРЫН АЖЛЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

### Ажлын цар хэмжээ:

Энэхүү ажил нь иргэдэд аюулгүй, тохилог орчинд амьдрах, ажиллах таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой.

Нийтийн зориулалттай орон сууцны засварын ажлыг хийж гүйцэтгэхдээ бусад ажилтай уялдуулан, тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын ажил үйлчилгээнд ямар нэгэн саад бэрхшээл гаргалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах.

1	Төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Хан-Уул Засаг дарбын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/178 дугаартай захирамж.
2	Байршил, барилгын хэмжээ	- Хан-Уул Дүүргийн 3 дугаар хороо 50-р байр - 15 дугаар хороо Модер таун 25-р байр, Жаргалан хотхон 1, 2, 49а, 49б байр - 19 дүгээр хороо 15.1, 15.2, 59, 87-р байр - 24 дүгээр хороо 107 дугаар байр
3	Зориулалт хүчин чадал	- Хан-Уул Дүүргийн 3 дугаар хороо 50-р байр - 15 дугаар хороо Модер таун 25-р байр, Жаргалан хотхон 1, 2, 49а, 49б байр - 19 дүгээр хороо 15.1, 15.2, 59, 87-р байр - 24 дүгээр хороо 107 дугаар байрнуудын дээвэр засварын ажил - Гүйцэтгэгч байгууллага зургийн шатанд илүү дэлгэрэнгүй талбайн судалгаа, хэмжилтийг хийж нарийвчлах.
4	Одоогийн байдал	- Барилгын дээврийн хучлага хар цаас хавагнах хөндийрсэн, хурын ус тогтдог, хашилага хана, сувгийн хоолойг өгсүүлж наасан хэсгийн наалт зай завсар гарсан. - Дээврийн төмөр зэвэрч муудсан.
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
6	Төслийн захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг дарбын Тамгын газар
7	Төсөл гүйцэтгэх байгууллага	- Барилга хот байгуулалтын Яамны сайдын тушаалаар батлагдсан "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл, барилгын ажил


		гүйцэтгэх, өргөх байгууламж, угсралт засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой.
8	Төсөл гүйцэтгэх үе шат	<ul style="list-style-type: none"> <li>- Талбайн судалгаа, хэмжилт хийх.</li> <li>- Хорооны Засаг дарга болон СӨХ-той заавал зөвшилцсний дараа ажлын тоо хэмжээг захиалагчид танилцуулах.</li> <li>- Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. /магадлал хийгдсэн байх/.</li> <li>- Төсөвт өртөг /магадлал хийгдсэн байх/.</li> </ul>
9	Төлөвлөлтөд тавигдах шаардлага	<p><b>Буулгах ажил:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хуучин одоо байгаа дулаалга болон хуйлмал материалан дээврийг буулгах.</li> <li>- Дээврийн хог шороог шүүрдэж цэвэрлэн ажилд бэлтгэх.</li> <li>- Барилгаас гарсан хог хаягдалыг ачиж зайлцуулах.</li> <li>- Шувуу нуруу дээврийн төмрийг буулгаж, хөгцөрч муудсан шувуу нуруу, нурууны хөлийг солих.</li> </ul> <p><b>Шинээр хийгдэх ажил:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дээврийн талбайн цементэн тэгшилгээг засварлах, шинээр хийх.</li> <li>- Ус тусгаарлагчийг зориулалтын дагуу хийж зөрүүлгийг 10см-ээс багагүйгээр хийж гүйцэтгэнэ.</li> <li>- Тагт, Агааржуулагчийг засварлаж ус тусгаарлагч уян резин материал дэвсэх.</li> <li>- Агааржуулагчийн малгайвчийг шинэчлэн засварлах.</li> <li>- Хавтгай дээвэрт мембранийг ашиглах талаар судалж танилцуулан зөвшилцэх.</li> <li>- Парапедны төмрийг буулгаж, буцааж суулгах дутуу хэсэгт гөлмөн төмрөөр төмөрлөх, шинэчлэх.</li> <li>- Шувуу нуруун дээврийн хөндийн салхивч агааржуулагчийг сайжруулах. Хэвлэмэл төмрийг солих. Ховоо хийж өгнө.</li> </ul>
10	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><b>Монгол Улсын хуулиуд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Барилгын тухай хууль</li> <li>- Бусад холбогдох хууль</li> </ul> <p><b>Норм, нормативууд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дээврийн ажил /БНБДЗ1-07-05/</li> <li>- БД 31-108-08</li> <li>- Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05</li> <li>- БД 23-103-10 Барилгын дулаан хамгаалалтын төлөвлөлт</li> <li>- MNS 3154-1981 40мм хүртэл диаметртэй арматуран гагнасан тор. Ерөнхий техникийн шаардлага</li> <li>- MNS 6303:2016 Дээвэр болон барилга байгууламжид хэрэглэх ус, уур тусгаарлах хуйлмал материал. Техникийн ерөнхий шаардлага</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцэх, магадлал хийх дүрэм</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм</li> </ul>

11	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	- Гадаргуугийн ус зайлуулах шийдлийг орчны байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх.
12	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.
13	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Дээврийн засварын ажилд хэрэглэгдэх материалууд нь бүгд гарал үүслийн гэрчилгээтэй, барилгын материалын лабораториор баталгаажсан сертификаттай, монгол улс болон олон улсын чанар стандартын шаардлагыг бүрэн хангасан байх.</li> <li>- Засварын ажилд хэрэглэгдэх машин механизмын аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах</li> <li>- Өндөрт ажиллах ХАБЭА-н дүрэм, журмыг чанд мөрдөх.</li> </ul>

- Зураг төсвийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, зориулалтыг өөрчлөхгүйгээр төсөвт өртөгт багтаах. Төсөвт өртөг хэтэрсэн тохиолдолд ажлын зураг батлагдахгүй болно.
- Зураг төсвийн болон ажил гүйцэтгэх явцад хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг хатуу мөрдөж ажиллах.
- Эрүүл аюулгүй, чанарын шаардлага хангасан материал сонгох /БНБД-д заасан/. Зөвшөөрөгдсөн лаборатори, гарал үүслийн, сертификаттай баталгаат материалыг ашиглах.

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Л.ОТГОНБАЯР

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Г.ТУЯАЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Г.ЛУВСАНЖАМЬЯН


Хан-Уул дүүргийн 15 дугаар хороо Модерн таун 25-р байр 1, 2-р орц, Жаргалан хотхон 1, 2, 49а, 49б байрны дээвэр засвар



Хан-Уул дүүргийн 19 дугаар хороо 15-1, 15-2, 59, 87 дугаар байрны дээвэр засвар



3 дугаар хороо 50 дугаар байрны дээвэр засвар



24 дүгээр хороо 107 дугаар байрны дээвэр засвар

